

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн  
нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/03/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Б.Должинжав

Утас: 70432545

цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар.....	16
4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа .....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага .....	17
4.4. Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Ст
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт -1	Санхүүгийн байдлын тайлан	9
Хүснэгт -2	Авлагын үлдэгдэл	10
Хүснэгт -3	Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хүснэгт -4	Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт -5	Аудитад хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Хүснэгт -6	Түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл	17



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.ТҮВШИНСАЙХАН ТАНАА

2022.03.25 № 2/104  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, зарцуулаагүй, сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагад алданги тооцоогүй, хугацаа хэтэрсэн зээлийн авлага барагдуулахад анхаарч ажиллаагүй, зардлыг ангилал хооронд нь гүйлгэн зарцуулснаар нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу тайлагнасан, төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим систем дэх мэдээлэл хангалтгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль холбогдох бусад хууль, журамтай нийцээгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	587,699.1	649,919.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	57,820.7	142,538.3
33	АВЛАГА	325,907.3	302,173.4
35	БАРАА МАТЕРИАЛ	203,971.2	205,208.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,513,537.5	5,523,078.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,513,537.5	5,523,078.9
39200	Биет хөрөнгө	5,073,723.5	5,050,843.9
39300	Биет бус хөрөнгө	439,814.0	472,234.9
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	6,101,236.6	6,172,998.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,065.5	14,741.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,065.5	14,741.5
41300	Өглөг	9,065.5	14,741.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,092,171.1	6,158,257.2
51	Засгийн газрын хувь оролцоо	6,092,171.1	6,158,257.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,465,163.0	2,465,163.0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,886,063.4	1,952,504.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,740,944.6	1,740,589.6
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	6,101,236.6	6,172,998.7

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,016,454.9	2,827,948.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	84,870.7	103,582.1
110	Орлогын албан татвар	47,696.7	56,721.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	47,696.7	56,721.5
113	Хөрөнгийн албан татвар	510.0	11,367.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,664.0	35,493.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,719,162.5	318,189.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,719,162.5	318,189.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,212,421.8	2,406,176.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,562,205.1	2,743,910.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,562,205.1	2,743,910.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,394,743.1	2,660,465.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,531,845.9	1,611,120.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,239.1	217,212.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,866.4	92,753.6
2104	Хангамж, бараа материалын зардал	89,960.4	198,449.7
2105	Нормативт зардал	84,934.8	127,006.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,048.4	9,013.6
2107	Томилолт, зочны зардал	2,274.0	2,862.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,471.7	76,300.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	337,102.3	325,747.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	167,462.0	83,445.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,454,249.8	84,038.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	17,426.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,454,249.8	66,611.4

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	4,637,245.4	4,637,245.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	675.8	675.8
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	4,637,921.3	4,637,921.3
9	Тайлант үеийн үр дүн	1,454,249.8	1,454,249.8
10	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	6,092,171.1	6,092,171.1
11	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	6,092,171.1	6,092,171.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-170.2	-170.2
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	6,092,000.9	6,092,000.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-355.0	-355.0
19	Тайлант үеийн үр дүн	66,611.4	66,611.4
20	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	6,158,257.2	6,158,257.2

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,364,758.2	2,588,405.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	84,870.7	103,582.1
110	Орлогын албан татвар	47,696.7	56,721.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	47,696.7	56,721.5
113	Хөрөнгийн албан татвар	510.0	11,367.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,664.0	35,493.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,130.0	13,108.9
1181	Газрын төлбөр	0.3	1,342.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	23,533.6	21,041.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,465.8	106,584.0
120	Нийтлэг татварын бус орлого	67,465.8	106,584.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,212,421.8	2,378,239.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,230,989.5	2,337,488.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,230,989.5	2,337,488.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,064,277.5	2,241,417.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,529,294.1	1,614,512.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,859.0	217,790.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,439.2	94,525.8
2104	Хангамж, бараа материалын зардал	51,210.1	60,919.2
2105	Нормативт зардал	93,403.0	114,955.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,632.2	8,107.1

2107	Томилолт, зочны зардал	2,274.0	2,862.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,421.2	84,860.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,744.6	42,884.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,712.0	96,071.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	133,768.7	250,916.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	157,689.4	139,099.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	157,689.4	139,099.2
2200	Дотоод эх үүсвэрээр	157,689.4	139,099.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-157,689.4	-139,099.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-55,993.0	-27,100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	55,993.0	27,100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-79,913.7	84,717.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	137,734.4	57,820.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	57,820.7	142,538.3

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,375,964,500.0	2,272,577,331.3	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,152,529,300.0	2,122,042,131.3	-30,487,168.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,117,208,000.0	2,087,661,231.3	-29,546,768.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,590,503,500.0	1,578,444,623.3	-12,058,876.7
210101	Үндсэн цалин	1,046,692,300.0	1,037,610,582.5	-9,081,717.5
210102	Нэмэгдэл	408,659,000.0	411,721,772.4	3,062,772.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.0	4,587,000.0	-957,000.0
210104	Урамшуулал	88,002,300.0	88,571,394.4	569,094.4
210105	Гэрээт ажлын хөлс	41,605,900.0	35,953,874.0	-5,652,026.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	214,718,700.0	213,123,683.3	-1,595,016.7
210201	Тэтгэврийн даатгал	151,098,100.0	149,654,514.8	-1,443,585.2
210202	Тэтгэмжийн даатгал	15,905,100.0	15,932,348.7	27,248.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,724,200.0	12,719,218.9	-4,981.1
210204	Ажилгүйдлийн даатгал	3,181,100.0	3,165,236.6	-15,863.4
210205	Эрүүл мэндийн даатгал	31,810,200.0	31,652,364.3	-157,835.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,734,600.0	92,667,845.8	-66,754.3
210301	Гэрэл, цахилгаан	17,058,700.0	18,506,330.0	1,447,630.0
210302	Түлш, халаалт	74,119,500.0	73,297,835.0	-821,665.0
210303	Цэвэр, бохир ус	1,556,400.0	863,680.8	-692,719.2
2104	Хангамж, бараа материалын зардал	47,795,500.0	47,767,880.0	-27,620.0
210401	Бичиг хэрэг	7,716,100.0	7,637,400.0	-78,700.0
210402	Тээвэр, шатахуун	28,770,500.0	26,759,700.0	-2,010,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,058,900.0	8,263,400.0	2,204,500.0
210404	Ном, хэвлэл	370,900.0	370,900.0	0.0

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,398,500.0	3,397,680.0	-820.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,480,600.0	1,338,800.0	-141,800.0
2105	Нормативт зардал	96,961,000.0	82,062,210.0	-14,898,790.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,399,800.0	20,399,800.0	0.0
210502	Хоол, хүнс	71,696,000.0	56,798,110.0	-14,897,890.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,865,200.0	4,864,300.0	-900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,240,700.0	6,237,100.0	-3,600.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.0	1,000,000.0	0.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	267,000.0	267,000.0	0.0
210604	Урсгал засвар	4,973,700.0	4,970,100.0	-3,600.0
2107	Томилолт, зочны зардал	2,873,400.0	2,260,000.0	-613,400.0
210702	Дотоод албан томилолт	2,873,400.0	2,260,000.0	-613,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,805,300.0	16,523,450.0	-281,850.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,455,200.0	13,379,200.0	-76,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,721,000.0	1,721,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	291,100.0	290,510.0	-590.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,000.0	130,740.0	-79,260.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	52,000.0	-3,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.0	450,000.0	0.0
210807	Газрын төлбөр	123,000.0	0.0	-123,000.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.0	500,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,575,300.0	48,574,438.9	-861.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,568,700.0	38,567,976.9	-723.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,006,600.0	10,006,462.0	-138.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,321,300.0	34,380,900.0	-940,400.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,321,300.0	34,380,900.0	-940,400.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,047,800.0	21,107,400.0	-940,400.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,626,500.0	12,626,500.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	647,000.0	647,000.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	123,435,200.0	123,435,200.0	0.0
220001	Барилга байгууламж	55,000,000.0	55,000,000.0	0.0
221001	Их засвар	16,285,200.0	16,285,200.0	0.0
222001	Тоног төхөөрөмж	47,150,000.0	47,150,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	5,000,000.0	5,000,000.0	0.0

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000,000.0	27,100,000.0	-72,900,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000,000.0	27,100,000.0	-72,900,000.0
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,375,964,500.0	2,336,285,962.3	-39,678,537.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,572,488,400.0	1,556,458,207.9	-16,030,192.2
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,572,488,400.0	1,556,458,207.9	-16,030,192.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	656,642,200.0	647,273,231.4	-9,368,968.6
320001	Орон нутгийн төсвөөс	554,427,000.0	545,058,088.4	-9,368,911.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	102,215,200.0	102,215,143.0	-57.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,428,900.0	34,341,300.0	-5,087,600.0
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,428,900.0	34,341,300.0	-5,087,600.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	107,405,000.0	98,213,223.0	-9,191,777.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,605,000.0	1,605,000.0	0.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,800,000.0	96,608,223.0	-9,191,777.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	15,545,217.73	15,545,217.73
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	79,253,848.73	79,253,848.73
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	851.0	5,777.0	4,926.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.0	6.0	0.0
610001	Төсвийн байгууллага	6.0	6.0	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	142.0	133.0	-9.0
620001	Удирдах ажилтан	13.0	13.0	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	76.0	76.0	0.0
620003	Үйлчлэх ажилтан	31.0	26.0	-5.0
620004	Гэрээт ажилтан	22.0	18.0	-4.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Тайлант он
ЫИ	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	217,863,207.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	209,663,227.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	161,219,957.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,067,515.0
210102	Нэмэгдэл	36,067,515.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,666,344.0
210201	Тэтгэврийн даатгал	4,666,344.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,858,000.0
210302	Түлш, халаалт	1,858,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,731,234.9
210401	Бичиг хэрэг	823,232.0

210402	Тээвэр, шатахуун	3,490,912.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,217,083.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,200,007.9
2105	Нормативт зардал	32,893,430.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,893,430.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.0
210604	Урсгал засвар	2,500,000.0
2107	Томилолт, зочны зардал	602,000.0
210702	Дотоод албан томилолт	602,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,337,433.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,337,433.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	564,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	564,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,443,270.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,023,270.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,623,270.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,400,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,420,000.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,420,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,199,980.0
2200	Дотоод эх үүсвэрээр	8,199,980.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,199,980.0
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	217,863,207.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	217,863,207.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,200,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	73,158,171.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,062,414.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,564,622.0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	70,878,000.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, сумын нэгдсэн төсөв баталсан тогтоол шийдвэр, түүвэрт хамрагдсан ЗДТГ, ИТХ, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдэд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 3 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 14-ны өдөр 1/49 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Буянт сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Төрийн албан хаагчдыг чадавхижуулж, иргэдэд ил тод, тэгш хүртээмжийг бий болгож, орон нутгийн хөгжлийг цогцлоон бий болгоход оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг үйл ажиллагааны стратегийн зорилтын "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", сумын засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр нийт 11 зорилт 125 арга хэмжээг төлөвлөж 72.1 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*
- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Сумын хэмжээнд тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журмын дагуу “цахим Э-тайлан” программ хангамж ашиглан санхүүгийн тайлан нэгтгэсэн байна.

Буянт суманд 2021 онд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон бусад байгууллагаас хяналт шалгалт хэрэгжүүлээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд түүвэрт хамруулан гүйцэтгэж буй байгууллага, тусгай сангийн ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 2376.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 47.5 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 38.0 сая төгрөгөөр тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Буянт сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71.8 сая төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгийн данстай холбоотой байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	57,820.7	142,538.3	84,717.6	247%
Авлага	325,907.3	302,173.5	-23,733.8	93%
Бараа материал	203,971.2	205,208.0	1,236.8	101%
Үндсэн хөрөнгө	5,513,537.4	5,523,078.9	9,541.5	100%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,101,236.6</b>	<b>6,172,998.7</b>	<b>71,762.1</b>	<b>101%</b>
Богино хугацаат өр төлбөр	9,065.5	14,741.5	5,676.0	163%
Цэвэр хөрөнгө, өмч	6,092,171.1	6,158,257.2	66,086.1	101%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,101,236.6</b>	<b>6,172,998.7</b>	<b>71,762.1</b>	<b>101%</b>

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 57.8 сая төгрөг байсан бол оны эцэст 142.5 сая төгрөг болж 84.7 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дэх 142.5 сая төгрөгийн 63.3 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 14.6 сая төгрөг нь ОНХС-ийн дансанд, 64.6 сая төгрөг нь СХС-ийн дансанд тус тус үлдсэн байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 325.9 сая төгрөг байсан бол оны эцэст 302.2 сая төгрөг болж 23.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>АВЛАГА</b>	<b>325,907.3</b>	<b>302,173.5</b>	<b>-23,733.8</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,151.4	143.5	-1,008.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	27,937.0	27,937.0
Татаас, санхүүжилтийн авлага	3,480.6	0.0	-3,480.6
Байгууллагаас авах авлага	7,615.4	18,523.9	10,908.5
Хувь хүмүүсээс авах авлага	52,802.9	52,802.9	0.0
Хувь хүмүүст олгосон зээл	260,856.9	202,766.1	-58,090.8

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 302.2 сая төгрөгийн авлагаас 64.2 сая төгрөгийн авлага нь он дамжсан, насжилт өндөртэй, зарим авлагын эзэн холбогдогч нь тодорхойгүй байна. Үүнээс сум хөгжүүлэх сангийн 26 зээлдэгчийн 58.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, ОНХС-аас жишиг хашааны 5.2 сая төгрөгийн насжилт өндөртэй авлага дийлэнхийг эзэлж байна.

### **3.5.3 Бараа материал**

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 204.0 сая төгрөг байсан бол оны эцэст 205.2 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 283.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 19.3 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, 301.7 сая төгрөгийн бараа материал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

### **3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 6853.1 сая төгрөг байсан бол оны эцэст 7059.2 сая төгрөг болж 206.1 сая төгрөгөөр өсжээ. Үүнд төсвийн хөрөнгөөр 24.4 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авч 278.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 96.3 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан байна.

### **3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 9.1 сая төгрөг байсан бол оны эцэст 14.7 сая төгрөг болж 5.6 сая төгрөгөөр өссөн байна. Өр төлбөрийн үлдэгдэл дэх 14.7 сая төгрөгт эрүүл мэндийн төвийн 9.5 сая, ОНХС-ийн 4.0 сая төгрөгийн эмийн өр нь материаллаг нөлөө үзүүлж байгаа ба нийт өр төлбөрийн 91.8 хувийг эзэлж байна.

### **3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 6092.1 сая төгрөг байсан бол оны эцэст 6158.2 сая төгрөг болж 66.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 66.6 сая төгрөг бий болсон, өмнөх оны үр дүнд 0.5 сая төгрөгийн залруулга хийсэнтэй холбоотой байна.

## **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3377.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3377.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн нийт зарлагыг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 2/02 дугаар тогтоолоор 2216.9 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсантай холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 дугаар тогтоолоор нийт зардлыг 2376.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор сумын нийт төсвийн орлого, зарлагыг баталсан боловч нэгтгэн товчоолж орлого, зардлын дүнг батлаагүй, хоорондоо зөрүүтэй, зарим зардлын дүнг тогтоолд тусгаагүй байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2375.9 сая төгрөгийн төсөв баталснаас 1572.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 554.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 102.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 39.4 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 100.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 7.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл Хүснэгт-3		/мянган төгрөг/		
Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,375,965	2,336,286	-39,679	
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,572,488	1,556,458	-16,030	
Орон нутгийн төсвөөс	554,427	545,058	-9,369	
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	102,215	102,215	0	
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	39,429	34,341	-5,088	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,605	1,605	0	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,800	96,608	-9,192	

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1556.4 сая, орон нутгийн төсвөөс 545.1 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 102.2 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 34.3 сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 90.0 сая, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 8.2 сая, нийт 2336.3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, төлөвлөснөөс 39.7 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2272.6 сая төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 12.1 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1.6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.1 сая, нормативт зардлыг 14.9 сая, томилолт, зочны зардлыг 0.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.3 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 0.9 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардлыг 72.9 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласнаас шалтгаалсан байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж, хуваарилах Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хянахад анхны батлагдсан төсвөөс 221.7 сая төгрөг хэмнэж төлөвлөх байтал тодотголоор 159.1 сая төгрөг нэмж төлөвлөсөн, харин нийт зардлаас 103.4 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласнаас дүгнэхэд ЗГ-ын 43 дугаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Суурь орлогыг 130.9 хувиар буюу 26.4 сая төгрөгөөр, үүнээс татварын орлогыг 133.8 хувиар буюу 26.2 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 102.7 хувиар буюу 0.2 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлжээ.

Хүснэгт 4. Сумын суурь орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянга.төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>СУУРЬ ОРЛОГО</b>	85,545.0	111,952.9	26,407.9	130.9
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	77,395.0	103,582.1	26,187.1	133.8
110002	Үйл ажиллагааны орлого	2,000.0	29,156.6	27,156.6	1,457.8
110003	Хөрөнгийн орлого	20,000.0	20,956.3	956.3	104.8
110004	Хөрөнгө борлуулсны орлого	0.0	30.0	30.0	0.0
110008	Шууд бус орлого	12,600.0	6,578.6	-6,021.4	52.2
113002	Бууны албан татвар	1,000.0	960.0	-40.0	96.0
113004	Малд ногдуулах албан татвар	0.0	10,407.6	10,407.6	0.0
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	2,815.5	815.5	140.8
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	6,100.0	7,320.0	1,220.0	120.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,700.0	2,973.4	1,273.4	174.9

118101	Газрын төлбөр	9,269.0	1,342.9	-7,926.1	14.5
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,276.0	0.0	-1,276.0	0.0
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	16,050.0	15,290.2	-759.8	95.3
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	5,400.0	5,751.1	351.1	106.5
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	8,150.0	8,370.8	220.8	102.7
120	Нийтлэг татварын бус орлого	8,150.0	8,370.8	220.8	102.7
120003	Торгуулийн орлого	8,150.0	8,370.8	220.8	102.7

Эх сурвалж: Буянт сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орлого давж биелэхэд материаллаг нөлөө үзүүлсэн нь үйл ажиллагааны орлого 27.2 сая, малд ногдуулах албан татвар 10.4 сая төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 217.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлснээс 73.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 65.1 сая төгрөгийг дээд шатны байгууллагаас, 8.8 сая төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос, 70.9 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус хууль, журамд нийцүүлэн орлогын эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг байгууллагаар задалбал ИТХ 0.2 мянга, эрүүл мэндийн төв 106.3 сая, ЕБС 32.5 сая, хүүхдийн цэцэрлэг 0.5 мянга, ЗДТГ 78.2 сая нийт 217.8 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, 203.5 сая төгрөгийг зориулалтын дагуу холбогдох арга хэмжээнд зарцуулж, 14.4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Буянт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна. Үүнд:

- Хувь иргэнтэй 10.0 сая төгрөгөөр “Сумын төвийн хог цэвэрлэх” ажил гүйцэтгүүлэхдээ ажлын даалгавар тодорхойгүй гэрээ байгуулж урьдчилгаа 6.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба ажил хүлээн авах комисс ямар ажлын даалгавар үндэслэн хүлээн авсан нь учир дутагдалтай байна. Мөн одоогоор дахин хогны эмх замбараагүй орчин бүрдсэн, гол устай ойрхон байршилд хогийн цэг бий болгосон, 2022 онд дахин хог цэвэрлэгээнд төсөв хөрөнгө төлөвлөсөн, цаашид ч тогтмол үргэлжлэх хандлагатай байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй үрэлгэн зарцуулагдах, түүнчлэн Байгаль орчны тухай хууль, Усны тухай хууль зөрчигдөж, ард иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл учирч болзошгүй байна.
- Сум хөгжүүлэх сангийн авлагад 2011-2021 онуудад олгосон 62 зээлдэгчийн 202.7 сая төгрөгийн зээлийн авлага байгаагаас 26 зээлдэгчийн 58.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл байна. Хугацаа хэтэрсэн зээлээс 2022 онд 7 иргэн нийт 15.2 сая төгрөгийн зээлийг бүрэн барагдуулж, одоогоор 19 иргэнтэй холбоотой 42.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй ба тухайн зээлийг барагдуулахад зохих арга хэмжээ авч ажиллаагүй байна.

- Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэхтэй холбоотой хувь иргэн, ААН, байгууллагуудаас 21.1 сая төгрөгийн бараа материал цугларч, 21.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.
- Тайланд хугацаанд 327 хүн ковид 19 цар тахлаар өвчилж 98.8 сая төгрөгийг эмчилжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эм тариа, нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл зэрэг үйл ажиллагааны зардал зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал хангалтгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2.8 сая төгрөгийн төлбөрийн акт барагдуулаагүй, өгсөн 2 зөвлөмжөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн буюу ОНХС-ийн гүйцэтгэлийн аудитаар 2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 худаг гаргах, 1 худгийн засвар, зам засварын ажлын гүйцэтгэл, хүүхдийн тоглоомын талбайд дутуу нийлүүлсэн тоглоом хүлээн авсан эсэхэд нарийвчилсан хяналт хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

#### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулан хянасан байна.

Аудитад хамрагдсан 3 байгууллага санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнэлттэй аудитаар баталгаажуулсан байна.

Аудитын дүгнэлт гарсан байгууллагуудад нийт 32.4 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 21.4 сая төгрөгийн 5 алдааг залруулж, залруулагдаагүй 11.0 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

*Аудитад хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл : Хүснэгт-5 /сая төгрөг/*

д/д

Үүнээс

	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЕБС	6	20.8	4	17.4					2	3.4
2	СӨБ	2	11.6	1	4.0					1	7.6
3	ЭМТ	1	0							1	0
	<b>Дүн</b>	<b>9</b>	<b>32.4</b>	<b>5</b>	<b>21.4</b>					<b>4</b>	<b>11.0</b>

*Эх сурвалж:* Буянт сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 258.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17.8 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 117.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 122.7 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. Үүнд:

1. Нэгтгэсэн санхүүгийн тайланд ИТХ 0.5 сая төгрөгийн авлага илүү бүртгэсэн, ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайланд 13.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлого, элэгдлийн зардлын дүнг тусгаагүй, ОНХС 4.0 сая төгрөгийн зардал, өр төлбөр дутуу тусгасан.
2. ЗДТГ шилэн дансны цахим системд дутуу оруулсан мэдээллийг бүрэн мэдээлж, аудитын явцад зөрчлийг арилгасан.

**Шийдвэрлэсэн нь:** Нийт 17.8 сая төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчлийг шалгагдагч байгууллагад танилцуулан 2022 оны 03 дугаар сарын 25-ны ..... тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

##### 4.2 Төлбөрийн акт

**4.2.1 Илрүүлэлт:** Сумын ЗДТГ-ын нягтлан бодогч өөртөө аймгийн Засаг даргын захирамж үндэслэн үндсэн цалингийн 20 хувиар мөнгөн урамшууллыг 1 сар давхардуулан илүү тооцож авсан 0.1 сая төгрөг, түүнчлэн тайлант онд 1 өдрийн албан томилолт илүү тооцож авсан 0.1 сая, нийт 0.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

**4.2.2 Илрүүлэлт:** Соёлын төв шинэ жилийн арга хэмжээнд зориулж гацуур мод худалдан авахаар тушаал гаргаж няравын дансруу 0.7 сая төгрөг шилжүүлсэн боловч гацуур мод аваагүй, данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

##### 4.3 Албан шаардлага

**4.3.1 Илрүүлэлт:** Шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал хангалтгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөв

**4.3.2 Илрүүлэлт:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн журам, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулах журамд нийцүүлж хэрэгжүүлээгүй зөрчил байна. Тухайлбал:

1. Буянт сумын хүүхдийн тоглоомын талбайд 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоглоомыг Эм Би Жи трейд ХХК-тай шууд гэрээ байгуулан худалдан авсан, түүнчлэн 10.4 сая төгрөгийн ажлыг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан зарлаж мэдээлээгүй атлаа сумын ЗДТГ-т албан ёсны бүртгэлгүй иргэдийн бүлэг нэрээр М.Кистаувайтай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нийт 30.4 сая төгрөгийн зөрчил байна.

2. Усны хайгуулын судалгаа, дүгнэлтгүй, худаг усны нэгдсэн кординат цэг, бүртгэл судалгаагүйгээр худаг ус гаргахад 29.0 сая төгрөг төлөвлөж зарцуулсан нь хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг нийтийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй, хүүхдийн тоглоомын талбайд худалдан авсан тоглоомын заримыг дутуу хүлээж авсан, сумын төвийн хог цэвэрлэх 10.0 сая төгрөгийн гэрээт ажлын даалгавар тодорхойгүй гэрээ байгуулсан зэргээс дүгнэхэд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд удирдлагын зүгээс хэрэгжүүлэх дотоод хяналт, хариуцлага сул байна.

3. Орон нутгийн хөгжлийн сангаас 2014 онд хэрэгжүүлсэн жишиг хашааны 9 иргэнтэй холбоотой 5.2 сая төгрөгийн он дамжсан, насжилт өндөртэй авлага барагдаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

**4.3.3 Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээнд алданги тооцох нөхцөл тусгаагүйгээс зээлийн барагдуулалт удааширч байгаа, түүнчлэн 19 зээлдэгчийн 42.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахад зохих арга хэмжээ авч ажиллаагүй, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа нь журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд ИТХ-аас хяналт, шалгалт хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв

#### 4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 4.4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Харьяа төсвийн байгууллагууд нь цалингийн зардлыг бодитой төлөвлөөгүй, түүнчлэн бүртгэл тооцооны хяналт суларснаас шалтгаалж цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг бүлэг дотроо ангилал хооронд, мөн цалингийн зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн зардалтай гүйлгэн зарцуулдаг зөрчил түгээмэл байна. Үүнээс шалтгаалж мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь зардлын ангилал үнэн зөв тайлагнагдаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавын дагуу зардлыг санхүүжүүлэх, бүртгэж тайлагнах, төсвийг бодитой төлөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийн тухай хууль, журмын дагуу төсөвт зохицуулалт хийх зэрэг шийдлүүдэд нягтлан бодогчдыг чиглүүлж, арга зүйгээр хангаж ажиллах.

##### 4.4.2 Төсөв тодотгон баталсан тогтоол шийдвэртэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Буянт сумын 2021 оны төсвийн тодотголыг сумын ИТХ-ын 08 дугаар сарын 17-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор баталсан боловч нэгтгэн товчоолж орлого, зардлын дүнг батлаагүй, нийт зардлын дүн нь санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй зөрүүтэй, зарим зардлын дүнг тогтоолд тусгаагүй зэрэг зөрчил байна.

**Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2 дугаар хавсралтаарх сум, дүүргийн төсвийн төслийг батлах маягтын дагуу төсөв батлах.

##### 4.4.3 ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шатахууны тооцоо бодолтод хяналт хэрэгжүүлээгүй, ковш, күлүгүр, протер авто машины шатахуун зарцуулалтын тайлан авч хянаагүй, батлагдсан төсөвт багтаан төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар захиран зарцуулаагүй, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй, бараа материал худалдан авсан тухай бүрт нярав орлого аваагүй, зарлагадахдаа нярав нь хүчин төгөлдөр санхүүгийн анхан шатны баримт үндэслэн зарлагадаагүй, үлдэгдлийг тооцоо бодоогүй, бараа материалын зарцуулалтад удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналт сул зэргээс шалтгаалж 47.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

**Зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах.

#### 4.4.4 ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** **Илрүүлэлт:** Баланс дахь авлагын үлдэгдлийг холбогдох байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй, ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт үр дүнгийн урамшуулал олгох тогтоол шийдвэрийг нотлох, дэмжих санхүүгийн баримт байхгүй зэрэг 1.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

**Зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах.

#### 4.4.5 Соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим мэдээллийн санд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, түүнчлэн аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан зэргийг мэдээлээгүй байна.

**Зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх, дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

ТТЗ болон түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа зөрчлийн нэгтгэл

Хүснэгт-6

/сая төгрөгөөр/

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	4	17.8	1	17.8			1	0.0	2	0.0
2	ЗДТГ	3	47.6	1	0.0	1	0.2			1	47.4
3	ИТХ	1	1.5							1	1.5
4	Соёлын төв	2	74.5			1	0.7			1	73.8
5	ОНХС	1	74.6					1	74.6		
6	СХС	1	42.9					1	42.9		

<b>Дүн</b>	12	258.9	2	17.8	2	0.9	3	117.5	5	122.7
------------	----	-------	---	------	---	-----	---	-------	---	-------

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН**


**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР: Б.ДОЛЖИНЖАВ**

Буянт сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүн 12 258.9 2 17.8 2 0.9 3 117.5 5 122.7

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР:

ТАЙЛАНГ БИЧСЭН:  
  
1197-9882  
1197-986454

Б.ДОЛЖИНЖАВ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/217-0428

Ховд

ХОА-2022/03/НА/СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн хөгжлийн санг түүвэрт хамруулан хянахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Усны хайгуулын судалгаа, дүгнэлтгүй, худаг усны нэгдсэн координат цэг, бүртгэл судалгаагүйгээр худаг ус гаргахад 29.0 сая төгрөг төлөвлөж зарцуулсан нь хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг нийтийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй, хүүхдийн тоглоомын талбайд худалдан авсан тоглоомын заримыг дутуу хүлээж авсан, сумын төвийн хог цэвэрлэх 10.0 сая төгрөгийн гэрээт ажлын даалгавар тодорхойгүй гэрээ байгуулсан,

2. Орон нутгийн хөгжлийн сангаас 2014 онд хэрэгжүүлсэн жишиг хашааны 9 иргэнтэй холбоотой 5.2 сая төгрөгийн он дамжсан, насжилт өндөртэй авлага барагдаагүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй,

3. Буянт сумын хүүхдийн тоглоомын талбайд 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоглоомыг Эм Би Жи трейд ХХК-тай шууд гэрээ байгуулан худалдан авсан, түүнчлэн 10.4 сая төгрөгийн ажлыг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан зарлаж мэдээлээгүй атлаа сумын ЗДТГ-т албан ёсны бүртгэлгүй иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн зэргээс дүгнэхэд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд удирдлагын зүгээс хэрэгжүүлэх дотоод хяналт, хариуцлага сул байна.

Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулах журам, жишиг хашааны гэрээний үүргийн холбогдох заалт, эргэн төлөлтийн хуваарь, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "Бүх шатны төсвийн захирагч нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах үүрэгтэй", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг

3

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/217/0428

Ховд

ХОА-2022/03/НА/СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн оруулбал зохих зарим мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны хухай хуулийн 4, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-д тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт сумын Засаг дарга Б.Түвшинсайхан, санхүү албаны дарга Б.Уртнасан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ



2

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/217-0428

Ховд

ХОА-2022/03/НА/-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Буянт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулан хянахад сум хөгжүүлэх сангийн зээлийн гэрээнд алданги тооцох нөхцөл тусгаагүйгээс зээлийн барагдуулалт удааширч байгаа, түүнчлэн 19 зээлдэгчийн 42.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулахад зохих арга хэмжээ авч ажиллаагүй, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа нь журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас хяналт, шалгалт хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журам, зээлийн гэрээний үүргийн холбогдох заалт, эргэн төлөлтийн хуваарь, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "Бүх шатны төсвийн захирагч нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах үүрэгтэй" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэн, хуулийн этгээдтэй нэг бүрчлэн тооцоо нийлж, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж үр дүн, тайланг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>3</sup> ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт сумын Засаг дарга Б.Түвшинсайхан, санхүү албаны дарга Б.Уртнасан, ОНХС хариуцсан нягтлан бодогч Ч.Айбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ



5

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061